

ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

**ХОВД СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН 2020 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН
САНХҮҮГИЙН ТАЙЛАН**

Аудитын код: ХОА-2021/52/СТА-ТШЗ

<p>Цахим хуудас: www.audit.mn</p> <p>Ховд хот 2021 он</p>	<p>Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар Утас: 70433061 Цахим хаяг: BoldbaatarKh@audit.gov.mn Аудитын менежер: А.Цэцэгсүрэн Утас:70432545 Цахим хаяг: Tsetsegsurena@audit.gov.mn Аудитор: Ц.Аззаяа Утас: 70432545 цахим хаяг: Azzaya.Ts@audit.gov.mn</p>
---	--

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Товчилсон үгийн жагсаалт

<i>АДБОУС</i>	<i>Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт</i>
<i>АОУС</i>	<i>Аудитын Олон Улсын Стандарт</i>
<i>УСНББОУС</i>	<i>Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт</i>
<i>ТТЗ</i>	<i>Төсвийн төвлөрүүлэн захирагч</i>
<i>ТШЗ</i>	<i>Төсвийн шууд захирагч</i>
<i>НББББ</i>	<i>Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг</i>
<i>ЗДТГ</i>	<i>Засаг даргын дамгын газар</i>
<i>ОНХС</i>	<i>Орон нутгийн хөгжлийн сан</i>
<i>БСУГ</i>	<i>Боловсрол соёл урлагийн газар</i>

Агуулга

1.Төрийн аудитын санал, дүгнэлт	3
2.Аудит хийсэн санхүүгийн тайлан	5
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан	5
2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан	6
2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан.....	7
2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	8
2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан	9
2.6 Аудит хийсэн нэмэлт санхүүжилтийн тайлан	10
3. Аудитын тайлан	10
3.1. Ерөнхий зүйл	10
3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй	10
3.3 Нягтлан бодох бүртгэлийн бодлого, дотоод хяналт.....	11
3.4. Материаллаг байдал	11
3.5. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	11
3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт	13
3.7. Шилэн дансны мэдээлэл	14
3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	14
3.9. Аудитын илрүүлэлт	14
Залруулсан алдаа	14
Зөвлөмж өгөхөөс бусад байдлаар шийдвэрлэсэн алдаа, зөрчил.....	
Аудитын зөвлөмж	14
3.10. Балансын дараах үйл явдал болон дараагийн аудитаар авч үзэх анхаарал татахуйц бусад чухал асуудлууд.....	14
4. Менежментийн захидал	14
5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	15

1. ТӨРИЙН АУДИТЫН САНАЛ, ДҮГНЭЛТ



ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД СУМЫН ХҮҮХДИЙН ЦЭЦЭРЛЭГИЙН
ЭРХЛЭГЧ Б.ШОЛПАНХАН ТАНАА

2021.02.25 № 2/136
танай _____ -ны № _____ -т

АУДИТЫН САНАЛ ДҮГНЭЛТ

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл материаллаг алдаагүй, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан холбогдох журамд нийцүүлэн үнэн зөв, шударга толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, гарын авлагын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Бусад мэдээлэл

Байгууллагын удирдлага бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Бусад мэдээлэл нь байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөний биелэлт, үйл ажиллагааны тайлан, хүүхдийн сурч боловсрох орчин, эрүүл аюулгүй байдал зэрэг санхүүгийн ба санхүүгийн бус мэдээллийг агуулсан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу үнэн зөв, шударга бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэж болох материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтуудыг хэрэгжүүлэх хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

021020945

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдаанаас үүссэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар түүнийг бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Х.БОЯДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН
2.1 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>31955115.4</u>	<u>29823767.0</u>
33	АВЛАГА	443383.4	0.0
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	443383.4	0.0
35	БАРАА МАТЕРИАЛ	31511732.0	29823767.0
354	Хангамжийн материал	31511732.0	29823767.0
35410	Бичиг хэргийн материал	0.0	36000.0
35420	Аж ахуйн материал	373550.0	72000.0
35440	Түлш, шатах тослох материал	2075000.0	1032000.0
35460	Хүнсний материал	4746827.0	1524912.0
35470	Бусад хангамжийн материал	24316355.0	27158855.0
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>201433351.6</u>	<u>205246904.8</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	201433351.6	205246904.8
392	Биет хөрөнгө	193479551.6	197293104.8
39201	Барилга, байгууламж, орон сууц	170272480.0	170272480.0
39202	Хуримтлагдсан элэгдэл	-2837874.7	-5675749.4
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	29912756.0	34426756.0
39206	Хуримтлагдсан элэгдэл	-22830643.0	-25456036.7
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	23040566.0	29843282.8
39208	Хуримтлагдсан элэгдэл	-17830551.7	-19870446.8
39214	Бусад үндсэн хөрөнгө	13268990.0	13268990.0
39217	Ном	483829.0	483829.0
393	Биет бус хөрөнгө	7953800.0	7953800.0
39301	Програм хангамж	457000.0	457000.0
39303	Бусад биет бус хөрөнгө	7496800.0	7496800.0
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>233388467.0</u>	<u>235070671.8</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>180085.0</u>	<u>248694.0</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	180085.0	248694.0
413	Өглөг	180085.0	248694.0
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	43555.0	112164.0
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	106750.0	106750.0
4136	Бусад өглөг	29780.0	29780.0
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	29780.0	29780.0
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>233208382.0</u>	<u>234821977.8</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	233208382.0	234821977.8
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	59467248.0	59467248.0
51101	Өмч: - төрийн	59467248.0	59467248.0
512	Хуримтлагдсан үр дүн	62335613.2	63949209.0
51210	Өмнөх үеийн үр дүн	62335613.2	62335613.2
51220	Тайлант үеийн үр дүн	0.0	1613595.9
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	111405520.8	111405520.8
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>233388467.0</u>	<u>235070671.8</u>

2.2 АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	240658281.0	300270566.8
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	6337756.0	7477216.8
120	Нийтлэг татварын бус орлого	6337756.0	7477216.8
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	6337756.0	7477216.8
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	6337756.0	7477216.8
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	234320525.0	292793350.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	220273400.0	276759900.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	220273400.0	276759900.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	4484450.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	4050000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	434450.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	14047125.0	11549000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12231500.0	11549000.0
132007	Орон нутгийн хөгжлийн сангаас санхүүжих	1815625.0	0.0
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	233195893.2	298656971.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	233195893.2	298656971.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	233195893.2	258041077.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	156648913.0	190956091.3
210101	Үндсэн цалин	107733831.0	139187968.3
210102	Нэмэгдэл	20075112.0	39337079.4
210104	Урамшуулал	14614329.0	12431043.6
210105	Гэрээт ажлын хөлс	14225641.0	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	21182935.0	24527385.9
210201	Тэтгэврийн даатгал	14907813.6	16642604.9
210202	Тэтгэмжийн даатгал	1568780.4	2088859.6
210203	ҮОМШӨ-ний даатгал	1255024.3	1406502.2
210204	Ажилгүйдлийн даатгал	313756.1	500228.0
210205	Эрүүл мэндийн даатгал	3137560.7	3889191.2
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	14007080.0	12562912.0
210301	Гэрэл, цахилгаан	953080.0	1221181.0
210302	Түлш, халаалт	12734000.0	10931731.0
210303	Цэвэр, бохир ус	320000.0	410000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	4988740.0	3353150.0
210401	Бичиг хэрэг	729060.0	1207600.0
210402	Тээвэр, шатахуун	767380.0	525000.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	115000.0	58600.0
210404	Ном, хэвлэл	0.0	26000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	0.0	148400.0
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	3377300.0	1387550.0
2105	Нормативт зардал	27018850.0	16485575.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	0.0	1660100.0
210502	Хоол, хүнс	26008850.0	14143875.0

210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1010000.0	681600.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1922610.8	0.0
210604	Урсгал засвар	1922610.8	0.0
2107	Томилолт, зочны зардал	112000.0	0.0
210702	Дотоод албан томилолт	112000.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	0.0	246100.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	0.0	46100.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	0.0	200000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7314764.4	9909863.6
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1021250.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	162000.0	2406700.0
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	6131514.4	7503163.6
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	40615893.2
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	40615893.2
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	40615893.2
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	7462387.8	1613595.9
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	7462387.8	1613595.9

2.3 АУДИТ ХИЙСЭН МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

төгрөгөөр

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	232504900.0	292793350.0
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	232504900.0	292793350.0
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	220273400.0	276759900.0
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	220273400.0	276759900.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	0.0	4484450.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	0.0	4050000.0
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	0.0	434450.0
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	12231500.0	11549000.0
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	12231500.0	11549000.0
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	232504900.0	292793350.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	232504900.0	292793350.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	232504900.0	252177456.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	152425189.0	190603495.7
210101	Үндсэн цалин	103510107.0	127133631.6
210102	Нэмэгдэл	20075112.0	49164164.1
210104	Урамшуулал	14614329.0	14305700.0
210105	Гэрээт ажлын хөлс	14225641.0	0.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	24920311.0	24348489.1
210201	Тэтгэврийн даатгал	16617811.0	17228309.8
210202	Тэтгэмжийн даатгал	2002700.0	1812862.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1733500.0	1442529.7

210204	Ажилгүйдлийн даатгал	415100.0	384342.3
210205	Эрүүл мэндийн даатгал	4151200.0	3480445.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	13816661.0	11517200.0
210301	Гэрэл, цахилгаан	1162661.0	1283200.0
210302	Түлш, халаалт	12274000.0	9834000.0
210303	Цэвэр, бохир ус	380000.0	400000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	829920.0	855800.0
210401	Бичиг хэрэг	101600.0	101600.0
210402	Тээвэр, шатахуун	358000.0	427800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	147100.0	83400.0
210404	Ном, хэвлэл	58000.0	58000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	165220.0	185000.0
2105	Нормативт зардал	37833832.0	14641872.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	33529.0	1621400.0
210502	Хоол, хүнс	36930200.0	12211072.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	870103.0	809400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	113800.0	4050000.0
210602	Тавилга	0.0	4050000.0
210604	Урсгал засвар	113800.0	0.0
2107	Томилолт, зочны зардал	112000.0	0.0
210702	Дотоод албан томилолт	112000.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	471500.0	312000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	271500.0	112000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000.0	200000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	1981687.0	5848600.0
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	1205299.0	0.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	776388.0	5848600.0
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	0.0	40615893.2
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	0.0	40615893.2
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	0.0	40615893.2

2.4 АУДИТ ХИЙСЭН ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	62,335,613.2	233,208,382.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	62,335,613.2	233,208,382.0
C08	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	62,335,613.2	233,208,382.0
D01	2020 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	62,335,613.2	233,208,382.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	62,335,613.2	233,208,382.0
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	1,613,595.9	1,613,595.9

D09	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	59,467,248.0	111,405,520.8	63,949,209.0	234,821,977.8
-----	---------------------------------------	--------------	---------------	--------------	---------------

2.5 АУДИТ ХИЙСЭН ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Баглагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	288308900.0	247693006.8
21	УРСГАЛ ЗАРДАЛ	288308900.0	247693006.8
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	288308900.0	247693006.8
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	213855900.0	190603495.7
210101	Үндсэн цалин	127625900.0	127133631.6
210102	Нэмэгдэл	71924300.0	49164164.1
210104	Урамшуулал	14305700.0	14305700.0
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	28870600.0	24348489.1
210201	Тэтгэврийн даатгал	20316300.0	17228309.8
210202	Тэтгэмжийн даатгал	2138500.0	1812862.1
210203	ҮОМШӨ-ний даатгал	1710800.0	1442529.7
210204	Ажилгүйдлийн даатгал	427800.0	384342.3
210205	Эрүүл мэндийн даатгал	4277200.0	3480445.3
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	11457900.0	11517200.0
210301	Гэрэл, цахилгаан	1223900.0	1283200.0
210302	Түлш, халаалт	9834000.0	9834000.0
210303	Цэвэр, бохир ус	400000.0	400000.0
2104	Хангамж, бараа материалын зардал	855800.0	855800.0
210401	Бичиг хэрэг	101600.0	101600.0
210402	Тээвэр, шатахуун	427800.0	427800.0
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	83400.0	83400.0
210404	Ном, хэвлэл	58000.0	58000.0
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	185000.0	185000.0
2105	Нормативт зардал	24882100.0	14207422.0
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1621400.0	1621400.0
210502	Хоол, хүнс	22451300.0	11776622.0
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	809400.0	809400.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	91100.0	0.0
210604	Урсгал засвар	91100.0	0.0
2107	Томилолт, зочны зардал	105200.0	0.0
210702	Дотоод албан томилолт	105200.0	0.0
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	343600.0	312000.0
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	143600.0	112000.0
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	200000.0	200000.0
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7846700.0	5848600.0
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7846700.0	5848600.0

	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	288308900.0	247693006.8
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	276759900.0	236144006.8
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	276759900.0	236144006.8
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	11549000.0	11549000.0
132001	Орон нутгийн төсвөөс	11549000.0	11549000.0

2.6 АУДИТ ХИЙСЭН НЭМЭЛТ САНХҮҮЖИЛТИЙН ТАЙЛАН

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,050,000.0
21	УРСГАЛ ЗАРДАЛ	4,050,000.0
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	4,050,000.0
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	4,050,000.0
210602	Тавилга	4,050,000.0
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,050,000.0
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	4,050,000.0
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	4,050,000.0

3. АУДИТЫН ТАЙЛАН

3.1. Ерөнхий зүйл

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүгнэлтийг Цэцэрлэгийн эрхлэгч Б.Шолпанхан танд танилцуулж байна.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтад хийсэн үнэлгээ, аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал бүхий аудитын дүгнэлт түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан толилуулав.

Аудитын тайланд шалгагдагч төсвийн хөрөнгийн зарцуулалт, хоол хүнсний зардал, шатахууны зарцуулалтын талаар өгсөн зөвлөмжүүдийг менежментийн захидалд тусгасан болно.

Аудитыг 2021 оны 02 дугаар сарын 22-ноос 2021 оны 02 дугаар сарын 25-ны хооронд Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Ц.Аззаяа хариуцаж хэрэгжүүлэв.

3.2. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүй

Хүүхдийн сурах үйл хөгжлийг дэмжиж сургалтын чанарыг сайжруулан, багш ажилтны ёс зүйг эрхэмлэн ажлын байранд хөгжүүлэх, багш ажилчид болон хүүхдийн эрүүл мэндийг сахин хамгаалах, урьдчилан сэргийлэх зорилго дэвшүүлэн ажиллаж байна. Үүнд:

- Тойргийн 5 настай хүүхдийг цэцэрлэгт бүрэн хамруулах
- Цэцэрлэгийн өөрийн үнэлгээг хамтын оролцоотой хийж, үйл ажиллагааг сайжруулах

- “Чадварлаг багш”, “Авьяас”, Номын гэгээ, “Хүүхэд бүр цэцэрлэгт” дэд хөтөлбөрийг хэрэгжүүлэн хүүхдийн хос хэлээр өөрийгөө илэрхийлэх чадварт сургах
- Багш ажилтныг ажлын байранд тасралтгүй хөгжүүлэх, мэдээлэл харилцаа холбооны технологийн ур чадварыг хөгжүүлэн хүний нөөцийг чадавхжуулах
Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:
 - Засгийн газрын 2019 оны 472 дугаар тогтоолоор “Төрийн албан хаагчийн цалингийн сүлжээ, хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
 - Засгийн газрын 2020 оны 11 дүгээр сарын 183 тоот “бүх нийтийн бэлэн байдлын зэрэгт шилжсэнтэй холбогдуулан эдийн засгийг дэмжих чиглэлээр авах зарим арга хэмжээний тухай”
 - Засгийн газрын 2020 оны 1 дүгээр сарын 10 тоот “төрийн болон орон нутгийн өмчийн талаар авах зарим арга хэмжээний тухай

3.3 Нягтлан бодох бүртгэлийн үндсэн бодлого, дотоод хяналт

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй.

Тус байгууллага нь өөрийн онцлогт тохирсон Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг боловсруулж баталж мөрдөөгүй байна.

Аймгийн ЗДТГ-ын дэргэдэх Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2020 онд тус байгууллагад дотоод хяналтыг 2016-2019 оны үйл ажиллагаанд хяналт хийгдэж нийт 4868.5 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 4868.5 мянган төгрөгийн зөрчилд 7 төлбөрийн акт, 1 зөрчлийг арилгуулахаар зөвлөмж бичиж төлбөрийн акт, зөвлөмжийн хэрэгжилтийг бүрэн хэрэгжүүлэн ажилласан байна.

Байгууллагын дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд Дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

3.4. МАТЕРИАЛЛАГ БАЙДАЛ

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт орлогыг сонгож, эрсдэлийн түвшинг “Дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 240658.2 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 2406.5 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцсон.

Харин гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангийн нийт орлогын 300270.5 мянган төгрөгөөс 1 хувиар тооцон 3002.7 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тооцлоо.

3.5. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ҮЗҮҮЛЭЛТҮҮД

Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 1682.2 мянган төгрөгөөр буюу 0.7 хувиар өссөн байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан авлага, бараа материал, үндсэн хөрөнгө, өр төлбөрийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт /мянган төгрөг/

Тайлангийн үзүүлэлтүүд	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
------------------------	----------------	-----------------	----------

Авлага	443.3	0	-443.3	-100%
Бараа материал	31511.7	29823.7	-1687.9	-5.4%
Үндсэн хөрөнгө	201433.3	205246.9	3813.5	1.9%
НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	233388.4	235070.6	1682.2	0.7%
Богино хугацаат өр төлбөр	180.0	248.6	68.6	38.1%
Цэвэр хөрөнгө, өмч	233208.3	234821.9	1613.5	0.7%
ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	233388.4	235070.6	1682.2	0.7%

Авлага дансны үлдэгдэл 0 болж 443.3 мянган төгрөгөөр буурсан нь нийгмийн даатгалын шимтгэлийн илүү төлөлтийг суутган төлж барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 29823.7 мянган төгрөг болж 1687.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант онд аж ахуйн материал, нүүрс, хүнсний материалын зарцуулалттай холбоотой байна. Тайваны хүүхдийг ивээх сангаас үнэ төлбөргүй ирсэн углаа дэвсээг бараа материалд 2825.0 мянган төгрөгөөр орлого авч, мах дутагдуулсан няравтай холбоотой акт тавигдсанаар 1241.0 мянган төгрөгөөр зарлага гарсан байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл оны эхэнд 201433.3 мянган төгрөг, оны эцэст 205246.9 мянган төгрөг болж 3813.5 мянган төгрөгөөр өссөн байна.

Үндсэн хөрөнгийн данс нь ОНХС-аас 4050.0 мянган төгрөгийн тавилга эд хогшил, өөрийн хөрөнгөөр 2632.0 тоног төхөөрөмж тавилга эд хогшил, БСУГ-аас 3499.0 мянган төгрөгийн компьютер, 1135.7 мянган төгрөгийн тавилга эд хогшлыг үнэ төлбөргүй шилжүүлэн авч хөрөнгө нэмэгдсэн байна.

Өр төлбөр оны эхэнд 180.1 мянган төгрөгийн ажилчидтай холбогдсон, бараа үйлчилгээний зардлын өглөг байсан ба тайлант онд 68.6 мянган төгрөгийн өр төлбөр нэмэгдэж 248.6 мянган төгрөгийн өр төлбөртэй байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 234821.9 мянган төгрөг болж тайлант онд 1613.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байгаа нь тайлант оны үр дүнгээс шалтгаалсан байна.

Ховд сумын цэцэрлэгийн 2020 оны санхүүгийн үр дүнгийн тайлангаар нийт орлого өмнөх оноос 59612.2 мянган төгрөгөөр буюу 24.7 хувиар өссөн нь тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого нэмэгдсэнтэй холбоотой байна.

Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан 59612.2 мянган төгрөгийн орлогоос 2498.1 мянган төгрөгөөр урсгал үйл ажиллагааны санхүүжилт буурч, 56486.5 мянган төгрөгөөр тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих орлого нэмэгдсэнээс шалтгаалсан байна.

Нийт зардал өмнөх оноос 64574.9 мянган төгрөгөөр буюу 27.7 хувиар өссөн, өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан цалин, шимтгэлийн зардал 34307.1 мянган төгрөг буюу 21.9 хувиар, бараа үйлчилгээний бусад зардал 2595.0 мянган төгрөг буюу 35.4 хувиар, бусад урсгал шилжүүлэг 40615.8 мянган төгрөг буюу 100 хувиар өссөн, нормативт зардал 10533.2 мянган төгрөг буюу 61 хувиар, эд хогшил, урсгал засварын зардал 1922.6 мянган төгрөг буюу 100 хувиар, байр ашиглалттай холбоотой тогтмол зардал 1444.1 мянган төгрөг буюу 9.6 хувиар, хангамж бараа материалын зардал 1635.5 мянган төгрөгөөр буюу 7.2 хувиар буурсан байна. Энэ нь Засгийн газрын 472 тоот тогтоолоор цалингийн сүлжээ, хэмжээ өөрчлөгдсөнтэй холбоотой байна.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар өмнөх оны үр дүн рүү хаасан бичилт хийгдээгүй байна.

3.6. Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт санхүүжилт

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төсвийн төлөвлөлт:

Тус байгууллагын 2020 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 288308.9 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 288308.9 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Аймгийн Боловсрол соёл урлагийн газрын шийдвэрээр Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны төсвийг 291093.3 мянган төгрөгөөр баталсан ч дахин тодотгол хийж хоолны зардлаас 2784.4 мянган төгрөг дутуу санхүүжүүлж 288308.9 мянган төгрөг баталсан байна.

Төсвийн гүйцэтгэл:

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 6 арга хэмжээг санхүүжүүлэхээр 288308.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 11549.0 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс 276759.9 мянган төгрөгийг тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжүүлэхээр тус тус төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр орон нутгийн төсвөөс 11549.0 мянган төгрөг, тусгай зориулалтын шилжүүлгээс 236144.0 мянган төгрөгийн санхүүжилт авч урсгал үйл ажиллагаанд 247693.0 мянган төгрөгийг зарцуулж 40615.8 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 247693.0 мянган төгрөг буюу 85.9 хувьтай байгаа нь үндсэн үйл ажиллагааны зардлыг 918.1 мянган төгрөгөөр, хоол хүнсний зардлыг 34767.1 мянган төгрөгөөр, тогтмол зардлыг 31.8, сургалтын зардлыг 4888.7, нүүдлийн бүлгийн зардлыг 10.0 мянган төгрөгөөр тус тус хэмнэж зарцуулсантай холбоотой байна.

Нийт төсвийн зардлын гүйцэтгэлийг дутуу зарцуулсан нь 1 хөтөлбөрийн 4 арга хэмжээ 16664.8 мянган төгрөгөөр хэмнэсэн байна. Хэмнэсэн шалтгаан нь 2020 онд Ковид-19 цар тахалтай холбоотой хичээл практик, нормын хувцас зэрэг зардлуудын зарцуулах эрхийг нээж өгөөгүй мөн хүүхдийн хоолны гүйлгээ хийгдээгүй, багш нарт илүү цаг болон нэмэгдэл цалин хөлс олгоогүйтэй холбоотой хэмнэлт гарсан байна.

Хүснэгт 3	Хөтөлбөр, арга хэмжээний хэмнэлт	/мян.төг/
код	хөтөлбөр, арга хэмжээ	мөнгөн дүн
80101	Үндсэн үйл ажиллагааны зардал	918.1
81807	Хоол хүнс	17051.4
81807	Хоол хүнс	17715.7
80109	Тогтмол зардал	31.8
81832	Нүүдлийн бүлгийн зардал	10.0
81835	Сургалтын зардал	4888.7
	ДҮН	40615.8

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Нэмэлт санхүүжилт:

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Ховд сумын Орон нутгийн хөгжлийн сангаас тавилга тоног төхөөрөмжийн үнэ болох 4050.0 мянган төгрөгийг цэцэрлэгийн нэмэлт дансанд шилжүүлжээ.

Үүнээс 4050.0 мянган төгрөгийг Нурмарал ХХК-нд шилжүүлж 4 нэр төрлийн 27 ширхэг тавилга тоног төхөөрөмж худалдан авсан байна.

3.7. Шилэн дансны мэдээлэл

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор батлагдсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 147 мэдээллээс хугацаандаа оруулсан 138 мэдээлэл байна. Цалингийн зардлаас бусад 5 сая төгрөгөөс дээш дүн бүхий орлого буюу сар бүрийн санхүүжилтийн орлогын 27 мэдээллийг шилэн дансны цахим хуудсанд байршуулаагүй байна.

Батлагдсан төсөв, худалдан авах ажиллагааны төлөвлөгөө, аудитын дүгнэлтийн мөрөөр хийж хэрэгжүүлсэн ажлын тайланг тус тус мэдээлээгүй байна.

3.8. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийн талаар 1 зөвлөмж өгөгдсөнийг аймгийн боловсрол соёл урлагийн газраас нэгдсэн журмаар НББББ бичиг боловсруулж баталж өгсөн тул зөвлөмжийг хэрэгжсэн гэж үзлээ.

Хүснэгт 4 Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн төлбөрийн акт, албан шаардлагын хэрэгжилт /сая.төг/

Үзүүлэлт	Өмнөх оны илрүүлэлт		Биелэлт		Зөрүү		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	1	0	1	0	0	0	100
Нийт дүн	1	0	1	0	0	0	100

3.9. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 3767.3 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс, 2825.0 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 942.3 мянган төгрөгийн 2 зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх зөвлөмж өглөө.

Залруулсан алдаа: Аудитаар хөрөнгө орлогод аваагүй 2825.0 мянган төгрөгийн алдаа гарсныг залруулсан болно.

Аудитын зөвлөмж: Аудитаар илэрсэн 942.3 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгав.

3.10. БАЛАНСЫН ДАРААХ ҮЙЛ ЯВДАЛ БОЛОН ДАРААГИЙН АУДИТААР АВЧ ҮЗЭХ АНХААРАЛ ТАТАХУЙЦ БУСАД ЧУХАЛ АСУУДЛУУД

Дараагийн аудитаар анхаарал татахуйц онц асуудал байхгүй гэж үзлээ.

4. МЕНЕЖМЕНТИЙН ЗАХИДАЛ

Менежментийн захидалд цаашид анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

1. ХҮҮХДИЙН ХООЛНЫ ЗАРДАЛТАЙ ХОЛБООТОЙ АСУУДАЛ

1.1. **Илрүүлэлт:** Хоол хүнсний зардлаас урсгал засвар, гэрэл цахилгааны зардалд гүйлгэн зарцуулсан байна.

- 1.2. Эрсдэл: Төсвийн хөрөнгийг үр өгөөж буурах
- 1.3. Өгсөн зөвлөмж: Төсвийн тухай хуулийн “16.5.5.батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалтыг мөрдөн ажиллах.
- 1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн

2. ШАТАХУУНЫ ЗАРЦУУЛАЛТЫН ТАЛААР.

2.1 Илрүүлэлт: Шатахуун зарцуулалтын 427.8 мянган төгрөгийн төсөвтэй байтал 1044.4 мянган төгрөгийн шатахуун зарцуулсан байна.

Эрсдэл: Төсвийн тухай хууль зөрчигдөх, үрэлгэн зардал гарах.

2.2 Өгсөн зөвлөмж: Төсвийг үр ашигтай хэмнэлттэй байхаар төлөвлөж зарцуулах, шатахууны зарцуулалтад тавих дотоод хяналтыг сайжруулах.

2.3 Байгууллагаас өгсөн хариу тайлбар: Хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2021 оны 5 дүгээр сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү. Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. АУДИТААР ИЛЭРСЭН АЛДАА, ЗӨРЧЛИЙН ЖАГСААЛТ

Огноо: 2021	Аудитын нэр:	Ховд сумын Хүүхдийн цэцэрлэгийн 2020 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ХОА-2021/52/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр:	Ховд сумын Хүүхдийн цэцэрлэг		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Хоол хүнсний зардлаас бусад зардалд гүйлгэн зарцуулсан.	325.7	Зөвлөмж өгөх	Цэцэрлэгийн эрхлэгч, нягтлан бодогч	Б.Шолпанхан, Х.Бүлдиршин
2	Шатахууны зардлыг батлагдсан төсвөөс хэтрүүлэн зарцуулсан.	616.6	Зөвлөмж өгөх		
3	Цэцэрлэгийн зөөлөн эдлэл орлого авч бүртгэж тайлагнаагүй.	2825.0	Залруулга		
ДҮН		3767.3			

ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР